

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-8

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн
72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн
эсэх, үргэлжлэв/ 4-8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
05 дугаар сарын 06-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 05 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж, Х.Тэмүүжин;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хэлэлцэх асуудлын 1 дүгээрт орсон Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хасаж, долоо хоногоор хойшлуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	7
Бүгд:	18

61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Б.Заяабал нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 72.2 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хэлэлцэх асуудлын 3 дугаарт орсон “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хасах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	7
Бүгд:	18

61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 66.7 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн

72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийн талаар боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Энхбаяр, Д.Ганбат нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 23 минут үргэлжилж, ирвэл зохих 22 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 05 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Гишүүдийнхээ мэндийг эрье. Өнөөдрийн Байнгын хорооны хурал эхэлж байна. 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц Дамдины Цогтбаатар, Жуковын Алдаржавхлан, Норовын Алтанхуяг, Энхтайваны Бат-Амгалан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дашдондогийн Ганбат, Батжаргалын Заяабал, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц 81,8 хувьтайгаар бүрдсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал байгаа. 1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах байгаа, Цогтбаатар нарын гишүүн 9 гишүүн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн хууль байгаа, хуулийн төсөл. 2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаар, ингээд энэ бол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэлийг ярьж, хэлэлцэхээр байж байгаа. 3 дахь асуудал Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан санал хэлэх гишүүд байна уу? Би энэ дээр тэгвэл, гишүүд санал хэлэх гишүүн байхгүй байгаа бол би сая хурал эхлэхийн өмнө товч юу яасан гишүүдтэй нэг асуудлууд ярилаа. Тэгэхлээр энд энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр асуудал дээр надад нэг горимын санал байна. Энийг би долоо хоногоор хойшлуулах санал гаргаж байна. Бас ажлын хэсгийг нэмээд ажиллаадхаач, энд зарим гишүүдтэй ярилцаж хэлэлцэхүйц асуудлууд байна гэж үзэж байгаа юм. Тийм учраас энэ дээр би долоо хоногоор хойшлуулъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулмаар байна.

Энэний зэрэгцээгээр энэ хэлэлцэх асуудлын 3 дугаарт Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар өргөн бүрэлдэхүүнтэй байгуулахаар болсон тул энэ хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулмаар байна. Уг нь бид Байнгын хороон дээрээ ажлын хэсэг байгуулна гэж байсан. Их Хурлын даргатай

ярьж байгаад ер нь энэ аягүй нарийн асуудал байна лээ. Тэгэхлээр ганц манай Байнгын хороон дээр биш, Их Хурлын даргын түвшинд ажлын хэсгээ өргөн байгуулаад явах нь аягүй чухал. Үндсэн хуулийн нарийн асуудал бидэнд яг яригдах гэж байна шүү дээ. Тийм учраас энэ 3 дугаар асуудлыг бас, 3 дугаар асуудал бол тусдаа. Ингээ тус тусад нь санал хураах нь зөв байх. Нэг нь өнөөдрийн юунаас, тэгье, тэгвэл ингээ.

Хэлэлцэх асуудлын 1, 3-ыг хасъя гэсэн томъёоллоор нэг асуудлаар тус тусад нь хураалгүйгээр нэгтгээд явчихъя. Тэгэхлээр, яг үнэн, энэ ингээ. Нөгөө гишүүд өөр, өөр саналтай, энэ 2 асуудлаар өөр, өөр саналтай байж болзошгүй учир тус тусад нь санал хураачихъя тэгэх үү? Тэр нь зөв юм байна. 1 дүгээр асуудлыг долоо хоногоор хойшлуулъя ажлын хэсгийг ажиллуулах үүднээс. Тийм учраас энэ удаагийн хэлэлцэх асуудлаас хасъя гэдгийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 61,1 хувиар санал дэмжигдлээ. Да.Цогтбаатар гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Заяабал гишүүн дэмжсэнд тооцоорой. Ингээд санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Энэ 3 дугаар асуудлыг Жагсаал, цуглааны тухай хуулийн асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Отгонбаяр гишүүн дэмжсэн байна. 61,1 хувиар санал дэмжигдлээ. Отгонбаяр гишүүн дэмжсэнийг дэмжсэнд тооцоод бүртгээрэй. Ганц асуудал үлдэж байна. 2 дугаар асуудал руугаа оръё.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх, үргэлжлэв/

2 дугаар асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийн талаар боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Байнгын хорооны, Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэнтэй холбогдуулан боловсруулж байгаа Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэлийн талаар хэлэлцэнэ. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Хамтдаа байна шүү энэ. Ганбат гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний, Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Одоо энийгээ бол агуулга, энэ явж байгаа процесс энэ тэрийг зарчмын хувьд сайшаан дэмжиж байна. Тэгэхдээ зүгээр Дэгийн хууль дээр яг боловсруулалтыг аль түвшиндээ яаж зохион байгуулах энэ тэр гээд жоохон тодорхойгүй л харагдаад байгаа юм. Тэгээд энэ суурь мэдээллүүдийг хаанаас бэлтгэж орж ирэв? Би зүгээр танин мэдэхүйн чанартай л юм ярьж байгаа юм. Хаанаас бэлтгэж орж ирэв? Эргээд энэ дээр ямар, ямар судалгаанууд ашигласан бэ? Бид хэд нөгөө энэ судалгаануудыгаа ийм дурдаад ч юм уу, эшлэл байдлаар ингээд оруулбал арай жоохон үндэслэлтэй болох болов уу л гэж бодоод байгаа юм. Тэрнээс биш зүгээр нэг Улсын Их Хурал ерөнхий байдлаар бичээгүй.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн зохицуулалтаа тайлбарлаад явж байгаа учраас эх сурвалж буюу эш татаж байгаа бичиг баримтууд маань ямар

бүтээлүүдээс эш татаж авсан юм, тэр зүйлүүдээ ингээд оруулж болох уу, үгүй юу? Тогтоол дээр нэг их тийм хязгаарлалт байхгүй байх л гэж би бодоод байгаа юм. Тэгээд энэ асуудлуудыг зүгээр 2 асуулт байна. Хэн боловсруулж, ямар цаашдаа энэ чинь нэг жишиг тогтох гээд л байна шүү дээ. Хэн боловсруулж цаашдаа орж ирэх юм бэ? Тэгээд ер нь энэ судалгааны эш таталтуудыг энэ дээр нь дурдаж өгч болох уу л гэдэг ийм л зүйлийг сонирхож асууя.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнээ энэ нөгөө уг асуудал нь өөрөө сууриараа Төрийн байгуулалтын байнгын хорооны асуудал. Тэгээд түрүүн хэлэлцэж байхад манай Байнгын хорооны гишүүдээс бид бас энэнтэй нь танилцах хэрэгтэй байна гэдэг утгаар бид энд зүгээр хэлэлцэж, танилцаад явж байгаа ийм процесс явж байгаа юм. Түүнээс асуулт бол тухайн холбогдох Байнгын хороондоо л хандах тийм асуудал байгаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Зарчмын хувьд Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байна. Үндсэн хуулийн цэц дээр Үндсэн хуулийн их суудлын маргаан өрнөх явцад Цэц бол Улсын Их Хурлын тогтоолын үндэслэл хэсгийг мэдээж хянаж үзэж таарна. Ингэхдээ мөн хууль тогтоогч юу бодож энэ тогтоолоо гаргав гэдгийг бидний үг хэл, яриа, протоколыг авч үзэх байх гэж итгэж найдаж, хүргүүлж, үндсэндээ бол Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдэд хандаж нэг үг хэлэх гэж байна.

Тэгэхээр хүний үндсэн эрхийн зөрчлийг үндэслэж Үндсэн хуулийн цэц дунд суудлын шийдвэрээ гаргасан. Их суудлын шийдвэр гаргах явцад энэ парламентын мөн чанарыг нэг ойлгож харгалзаж авч үзээсэй гэж бодож байна. Парламент бол 1 дүгээрт юуны урьд хууль тогтоох байгууллага. 2 дугаарт ард түмний төлөөллийн дээд байгууллага. Ард түмний төлөөллийн дээд байгууллага гэх хувьдаа 4 үндсэн төлөөллийг зүй зохистой жигд хангаж байж энэ нь хүлээн зөвшөөрөгдөх төлөөллийн хэв шинжээ хадгалж явдаг онцлогтой. 1 дүгээрт улс төрийн бодлогын төлөөлөл буюу улс төрийн нам түүний бодлогыг тээх мэргэжлийн professional улс төрч байх тэр хүчин зүйлийг харгалздаг, төлөөллийг хангах ёстой байдаг. 2 дугаарт газар нутгийн төлөөлөл. Өөрөөр хэлбэл Монгол Улс тархай бутархай, хүн амынх нь тал нь Улаанбаатар хотод төвлөрсөн, 21 аймагт суурьшсан ийм онцлогтой. Тийм учраас энэ газар нутгийн жигд төлөөллийг хангасан байх учиртай. 3-д сонирхлын бүлгүүдийн төлөөлөл. Өөрөөр хэлбэл ажил мэргэжил, нас, хүйс онцлогуудыг жигд төлөөлүүлж хангасан хангаж байх ёстой. Манай 24 оны парламентын тухайд Ази тивд дэх хамгийн их жендерийн зүй зохистой харьцааг хадгалж чадаж байгаа улсын тоонд орж байгаа. Энд бол энэ сонгуулийн тогтолцооны үр нөлөөлөл чухал байсан. 4 дүгээрт нь үндэстэн ястны төлөөлөл гэж ярьдаг. Өөрөөр хэлбэл олон угсаатан үндэстэн ястнаас бүрдсэн улсуудын хувьд хамгийн жижиг үндэстэн ястны төлөөлөл ч парламентад орсон байх тэр онцлогийг харгалздаг.

Тийм учраас ийм олон хүчин зүйлүүдийг хангах гэдэг нь энэ сонгуулийн тогтолцооны их онцлогоос хамаардаг. Хэрэв ганцхан хүнийг дугуйлна гэвэл энэ баланс алдагдана. Яагаад гэхээр цэвэр мажоритарар явж ирсэн өнгөрсөн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Б.Энхбаяр: Өнгөрсөн 32 жилийн улс төрийн туршлагыг харгалзаж авч үзэхэд манай улс 4 удаа жижиг пропорциональ, юу мажоритар тогтолцоогоор явуулсан байдаг. Энэ тогтолцооны үр дүнд ямар парламентууд бүрдээд байсан бэ гэхээр үндсэндээ 50-аас 90 хувьтай бизнесменүүдийн төлөөлөл гараад байсан юм. Өөрөөр хэлбэл хамгийн мөнгөтэй хэсэг энэ парламентад орж ирдэг ийм болчихсон байсан. Мэргэжлийн онцлог, жендерийн балансыг авч үзвэл 1-ээс 3 эмэгтэй л 76 дотор сонгогдож байсан. Яг эрчүүдтэй үзэж тэр тойргоос гарч ирж чадаж байсан. Тийм учраас энэ зөвхөн 1-ийг дугуйлна гэдэг энэ тогтолцоо өөрөө эмэгтэй хүйсийн сонгогдох тэр боломж, магадлалыг эрс бууруулдаг, эрс бууруулдаг. Тэр утгаараа саяын ярьж байгаа энэ балансууд алдагдах. Одоо ингээд аваад үзвэл манай 24 оны парламент.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Яах уу гүйцээгээд нэг удаа сунгаж болно Энхбаяр даргаа, гишүүнээ. Тэгье. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Одоо манай парламентыг авч үзвэл 30 орчим хувь нь эдийн засагч, 30 орчим хувь нь хуульч гэдэг юм уу, өөрөөр хэлбэл мэргэжлийн балансууд хадгалагдсан, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл ямар нэгэн хэмжээгээр орж ирсэн ийм төлөөлөлтэй байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл бид төлөөллийн хэв шинжээ энэ 126 би боломжийн хэмжээнд хангаж байгаа. Энэ төлөөлөл мэргэжил, хүйсийн баланс дээр сонгогч ард иргэд сэтгэл ханамжтай байгаа гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ төлөөллийн хэв шинжийг хамгийн зүй зохистой хангадаг тогтолцоо нь аль нь вэ гэдгийг Үндсэн хуулийн цэц харгалзаж авч үзээсэй. Хэрвээ энэ баланс алдагдвал дараагийн ирэх 10, 20 жилийн хугацаанд парламентын хүлээн зөвшөөрөгдөх легитим байдал сулрах нь байна шүү гэдгийг Цэц маань авч үзээсэй гэсэн ийм санал бодолтой байна.

Д.Цогтбаатар: Энэ яг үнэн. Энэ цаашдаа ингээд хэлэлцэгдээд явж байхад Их Хурлын гишүүдийн энэ хэлж байгаа юунууд протоколд үлдэж байгаа учраас эргээд авч үзэх, ялангуяа яг зүйл, заалт болгон дээр ярьж байхад энд юу ярьж байгааг авч үзэх ийм хүчин зүйлүүд бий болж байна гэж ойлгож байгаа. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Өнөөдөр уг нь Хууль зүйн байнгын хороогоор 3 асуудал хэлэлцэхээс нэг асуудал үлдэж байна л даа. 2 асуудал уг нь би хэлэлцэх ёстой л асуудал байсан гэж ойлгоод байна. Нэг нь Жагсаал цуглааны тухай хууль, нөгөөдөх нь Хууль тогтоомжийн тухай хууль байна шүү дээ. Өнөөдрийн энэ гишүүдийг хэлэлцэхийг хойшлуулна гэдгийг энэ асуудлыг оруулж ирж байгаа хариуцсан тэр улсууд нь яаж мэдээд байна вэ? Ирээгүй байна шүү дээ. Ирэхгүй байгаа байхгүй юу. Энд уг нь ямар ч шийдвэр гарч магадгүй гээд хүлээгээд зогсож байх ёстой. Тэгэхээр бид нарын ажиллаж байгаа байдал нэг иймэрхүү. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх энэ Хууль зүйн байнгын хороо бол өөрөө Улсын Их Хурлын бараг гал зуух, бараг уураг тархи гэж хэлж болно. Ийм л Байнгын хороо л доо.

Гэтэл энэ Байнгын хороогоор хэлэлцэгдэх ёстой юм нь хойшилдог. Хууль тогтоомжийн тухай хууль бол маш сайн хуулийн нэг. Энэ Сайнзориг гишүүн намайг ХЗБХ-ны дарга байхад миний зөвлөхөөр ажиллаад, бид хэд батлуулаад л явж байсан. Одоо энэ хууль хэрэгждэггүйгээсээ болоод хэн дуртай нь хэрэгжүүлэх үедээ хэрэгжүүлдэг, хэрэгжүүлэхгүй үедээ хэрэгжүүлэхгүй байдаг. Энэнээс болоод

парламент чинь парламент биш болчихоод байна шүү дээ. Энэ дээр бид ингэж нэг их байхгүй юм шиг ингэж болохгүй.

Нөгөө талаар Жагсаал цуглааны тухай хууль байна. Сүүлийн арваад жил жинхэнэ иргэд жагсаал, цуглаан хийж, өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлдэг энэ юм нь байхгүй болчихсон. Энэ чинь эргээд цаашаа нөлөөлөх юм нь энэ 2 том орны дунд оршиж байгаа газар зүйн байрлалын хувьд гарцгүй ийм улс орны хувьд тэр ардчилал гэдэг чинь бидний л энэ ард түмний тусгаар тогтнолын нэг баталгаа байхгүй юу. Ийм байж энэ юманд ингэж хандаж болмооргүй байна. Тэр бүх юмыг Улсын Их Хурал тэр хэдэн дарга нарт өгчхөөд, ингээд суугаад байж болохгүй Хууль зүйн байнгын хорооны даргаа. Би Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ ч гэсэн анхааруулъя.

Энэ хэлэлцэж байгаа асуудлаар ардчиллын чухал үзүүлэлтийн нэг бол сонгууль. Тэр тусмаа энэ парламентын сонгууль, бусад сонгуулиуд яаж явагдаад, иргэд яаж саналаа өгч байна вэ, чөлөөтэй өгч чадаж байна уу, үгүй юу, энэ бүх юм нь ард түмний хүсэл эрмэлзэл энэ парламентыг, энэ засгийг байгуулахад нь тусгаж байна уу, үгүй юу гэдэг юм харагдаж байх ёстой. Гэтэл бол одоо үгүй байна. Бид ингээд яривал дагуул нам гэдэг юм уу, ер нь намтай ч юм уу, намгүй ч юм уу ийм байдалтай болчихоод байна шүү дээ. Яг ингээд харвал. Нэг хэдэн бүлэглэсэн этгээдүүд толгой дээр гараад суучихсан, ард түмний хүсэл зорилго бол өгсөн санал энэ бүх юм бол амьдрал дээр хэрэгждэггүй, биелдэггүй юм байна. Би хэнээс.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг гүйцээж өгье.

Д.Ганбат: Энэ Цэцийн юмыг жоохон тодруулчихмаар байх юм. Энэ дээр бичсэнээр бол энэ тогтоол дээр энэ дүгнэлт гаргасанд, гаргаж байгаа юм нь энэ өгсөн санал өгч байгаа юм нь иргэдийн, сонгогчийн бүр боломж олгоод байгаа юм шигээр тайлбарласан байна л даа. Тийм яг тодорхой ингээд ойлгомжтой ийм зүйл бол энэ дотор арай харагдахгүй байна. Яг Төрийн байгуулалтын байнгын хороо яг юу гэж үзээд байгаа юм бэ, иргэд саналаа өгөхгүй байх эрхтэй юм уу, үгүй юм уу тэр жагсаалтад байгаа зарим нэг хүмүүст? Бид сонгуулийн үеэр бүгдийг нь дугуйлаагүй бол орхигдчихсон бол тэр саналын хуудсыг хүчингүй болгож байсан. Энэ дээр л маргаан гарсан юм байна шүү дээ. Хэн нэгэн хүнд саналаа өгөхгүй, хэн нэгэн намд өгөхгүй байж болно шүү дээ. Шахахгүй байж болно биз дээ иргэдийг. Хэн нэгэн хүнийг дугуйлаагүйн төлөө нөгөө.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Дахиад 1 минут сунгаж болж байгаа авах уу та? Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Сонгогч бүгдийг нь 9 хүн сонгох ёстой, 1 нам сонгох ёстой. Энэ юмаа хийгээгүй бол өөрт нь таалагдаагүй байсны төлөө энэ сонгуулийн нөгөө нэг хүн дутуу бөглөлөө гээд, нам дутуу бөглөлөө гээд тэр сонгуулийн саналын хуудас хүчингүй болж байна. Хуулиараа ч тийм байсан. Энэ нь зөв гээд байгаа юм уу, буруу гээд байгаа юм уу? Энийг би тодруулмаар байна. Энэ тогтоол дээр. Мэдэхгүй, хэнээс асуух юм.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүнээ энэ ийм шүү дээ. Энэ нөгөө одоо яг ярьж байгаа Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг чинь өмнөх хуралдаанаар хэлэлцчихсэн байхгүй юу. Одоо бол нөгөө тогтоолын төсөл нь л орж ирээд бид

танилцаж байгаа юм. Тэгээд гол хэлэлцсэн Байнгын хороо нь болохлоор Төрийн байгуулалтын байнгын хороо байгаад байгаа юм. Тийм. Бид энэ дээр жишээлбэл, энэ чинь нөгөө одоо яг энэ тогтоол дээр та нэмж санал хэлж барих юм байвал нэмж болно. Бид тэгвэл энийг тусгах гээд явна шүү дээ. Түүнээс бол энэ чинь асуудаг, хэлэлцдэг энэ юм нь дуусчихсан байгаад л байгаа байхгүй юу. Тэрэндээ л байгаа юм. Тийм. Тэгээд бид одоо энэ тогтоолынхоо төсөлтэй одоо бол боловсруулж орж ирээд л танилцаж байгаа ерөөсөө. Энд санал хураахгүй. Одоо энэ дээр чинь. Юун дээр ямар нэгэн санал хураалгахгүй энд танилцах процесс явж байгаа байхгүй юу. Түрүүний удаа хэлэлцээд дуусчихсан, санал хураачихсан байхгүй юу. Та надаас өнгөрчихсөн юмыг, би энийг процедурыг эргүүлж чадахгүй байгаад байна л даа.

Ганбат гишүүнээ нэг юмыг харин хэлмээр байна. Би сая нэгдүгээр асуудлыг би хойшлуулъя гэдэг бол энэ яг цэвэр миний субъектив санал. Яагаад гэхлээр яах аргагүй нэг удаа ахиад нэг хэлэлцээд, дараагийн удаа халуун байсан ч орж ирээд хэдүүлээ хэлэлцэнэ. Тэгээд хаашаа явдаг түүгээрээ л явна биз. Би энэ удаа ажлын хэсгийг ахиад нэг нэмээд ажиллаад үзээч гээд зүгээр боломж олгож байгаа. Түүнээс энэ хууль дээр жишээлбэл өчигдөр гэхэд манай өрөөнд бүгдээрээ сууцгаагаад, бид ажиллацгаасан шүү. Тэгээд мэдээж ажиллаж байхад наана, цаана ахиад нэмээд санал авах юм сүүлийн минутад гарч болно. Тэр гарахлаар нь л би хойшлуулъя гэдэг горимын санал яг Байнгын хорооны даргын хувьд би гаргалаа.

3 дахь асуудал нь, тэр сая хасчхаж байгаа 3 дахь асуудал бол Ганбат дарга ийм юм шүү. Энэ ерөөсөө асуудлын агуулга сая ярилцах гээгүй, ажлын хэсэг байгуулах Байнгын хорооноос байгуулах байсныг өчигдөр би Их Хурлын даргатай ярьж байгаад Их Хурлын дарга байгуулаад, өргөн хүрээнд байгуулахаар болчхоод хойшлуулж байгаа юм. Түүнээс энэ дээр өөр нэг их тийм зарчмын асуудал эд нар бол байхгүй байгаа. Гэхдээ Ганбат гишүүний нэг юуг бол би саналыг дэмжиж байна. Юу гэвэл ер нь Их Хурал мэдээж хариуцлагатай бид ажиллах ёстой. Энэ дээр аливаа юмнууд дээрээ бас зарим асуудлууд удаашраад гацаад ингэж байгаа юмнууд байгаа. Тэгээд энийгээ ялангуяа хуралд хэдүүлээ бүгдээрээ л идэвхтэй оролцож, асуудлуудаа шийдээд явж байх ёстой. Тэгэх гэж л сонгогдсон. Тэгээд хуралдаа бүгдээрээ идэвхтэй оролцоод явж байх ёстой гэдэг энэ бол дээр санал нэг байна.

Өнөөдрийн тогтоолын төсөлтэй, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэнтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

15.28 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

